



The **AMERICAN CHAMBER** of Commerce in Mongolia

e-journal AMCHAM CSR

Дугаар 07 | 2022 оны 6-р сар



Редакцын зурвас

Монгол дахь Америкийн Худалдааны Танхим ("АмЧам Монгол"-оос) гаргадаг CSR-e-Journal сэтгүүлийн №7 дугаарыг цахим болон хэвлэмэл хэлбэрээр уншигчдын хүртээл болгоход таатай байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд үүрэг, хариуцлагаа ухамсарлан, олон нийтэд урам зориг өгч байдаг манлайлагчид, гишүүн байгууллагуудад бид үргэлж талархаж явдаг. 21-р зуунд бизнесүүд нийгмийн харуцлагыг олон төрлийн ажил хэрэгтээ шингээж, хүрээлэн буй орчноо хамгаалах, нийтийн сайн сайхны төлөө, нийгмийн эрүүл мэнд, хүн амын боловсролыг дэмжих зэрэг олон ажлуудыг амжилттай хийж болохыг манай гишүүн байгууллагууд удаа дараа харуулсаар ирлээ.

АмЧам Монголын "CSR e-Journal" нь эдгээр санаачилга, тэдгээрийн цаана өрнөсөн үйл явдлуудыг онцлон харуулахыг зорьдог. Бидний энэ шинэ дугаарт эдгээр гэгээлэг түүхүүдийг уншигч таньтай хуваалцах гэж буй нь нэр төрийн хэрэг юм.

2022 оны 7-р дугаарт манай хүндэт гишүүн байгууллагуудын гүйцэтгэсэн олон шинэ төсөл, арга хэмжээ багтсан болно. Хамтдаа мод тарихаас эхлээд залуучуудын боловсролыг дэмжих, олон хүний амь насыг аварсан доноруудын тухай, хүүхэд багачуудыг хамгаалсан төсөл, байгаль орчноо хамгаалсан гэх мэт олон үйл ажиллагааны тухай та дараагийн хуудаснуудаас уншиж танилцаарай.

Манай сэтгүүлийн шинэ дугаар танд таалагдаж, сайн сайхныг түгээх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх урам зориг авна гэдэгт гүнээ итгэж байна.

АмЧам Монгол
Олон нийт, харилцаа хариуцсан захирал
Л. Эрдэнэбилэг

“ИНВЕСКОР ББСБ” ХК НЬ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЗОРИЛГОТой LENDAHAND ПЛАТФОРМООР АМЖИЛТТАЙ САНХҮҮЖИЛТ БОСГОЛОО.

Зарчим 1 Байгаль орчноо хамгаалах	Зарчим 2 Хүний эрх, нийгмийг хамгаалах	Зарчим 3 Соёлын өвийг хамгаалах	Зарчим 4 "Ногоон Эдийн Засаг"-ийн өсөлтийг дэмжих
Зарчим 5 Санхүүгийн хүртээмжийг дэмжих	Зарчим 6 Ес зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих	Зарчим 7 Ил тод байдал, хариуцлагыг дэмжих	Зарчим 8 Манлайлан үлгэрлэх

“Инвескор ББСБ” ХК нь Нидерланд улсын “Lendahand” краудфандингийн платформуор дамжуулан нийт 2.5 сая америк долларын санхүүжилтийг босгохоор боллоо. Одоогийн байдлаар санхүүжилтийн эхний транч болох 236 мянга гаруй ам. долларыг амжилттай татан төвлөрүүлээд байна.

“Lendahand” краудфандингийн платформ нь нийгэм, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх (ажлын байр шинээр бий болгох, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, хөгжиж буй орнууд дахь ядуурлын түвшинг бууруулах гэх мэт) зорилготой төсөлд эх үүсвэр татах боломж бүрдүүлдэг ба өнөөдрийг хүртэл 2,928 төсөлд амжилттай санхүүжилт татах гүүр болж, 1.2 сая хүний амьдралын түвшинд эерэг нөлөө үзүүлсэн байна.

“Lendahand” краудфандингийн платформ нь санхүүжилт татсан төслүүдээс нийгэм, байгаль орчинд үзүүлсэн эерэг нөлөөллийг буюу НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудыг тухайн санхүүжилтээр дамжуулан хэрхэн хэрэгжүүлснээ тайлагнах шаардлага тавьдаг бөгөөд “Инвескор ББСБ” ХК нь үр дүнгээ зохистой хэмжин, тайлагнаж нийгэм, байгаль орчиндоо эерэг нөлөө үзүүлэн, хувь нэмрээ оруулах юм.





Монгол дахь Америкийн Худалдааны Танхим нь АНУ-Монгол хоёр улсын худалдаа, бизнес ба эдийн засгийн өсөлт дэвшлийг түүчээлсэн 11 дэх жилтэйгээ золгож байгаа билээ. Манай худалааны танхим өнөөдрийн байдлаар 73 гишүүн байгууллагуудын хамтаар бизнесийн орчинг хөгжүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа идэвхтэй явуулахын зэрэгцээ нийгмийн хариуцлагын хүрээнд олон төсөл, ажлуудыг идэвх санаачлагтай зохион байгуулсаар байна. Эдгээр ажлууд нь олон нийт, нийгэм рүү чиглэсэн олон талын эерэг өөрчлөлт, сайн сайхны төлөө хийгддэг. Жил бүрийн 5-р сарыг бид Service Day буюу олон нийтэд үйлчлэх өдөр хэмээн тунхаглаж, гишүүдтэйгээ хамтран нийгэмд тулгамдаж буй олон асуудлуудыг тодруулж, өөрсдийн хувь нэмрийг оруулахыг зорьж байна. 2022 оны хувьд бид Service

Day өдөрлөгөөр үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 200 ширхэг агч, буйлс мод тарьж, Улаанбаатар хотод ногоон байгууламжийн хүртээмжийг өсгөхөд гар бие оролцсон явдалд сэтгэгдэл одоо хүртэл өндөр байна. Энэ удаагийн арга хэмжээг бодит ажил хэрэг болгоход гүн туслалцаа үзүүлсэн ивээн тэтгэгчид болох **Faro Foundation, Monpolymet Group, MSM, ThieSS** компаниудын удирдлага, хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлж байгааг хүлээн авна уу. Уг арга хэмжээнд гишүүн байгууллагуудын 80 гаруй төлөөлөгчид оролцож, 200 ширхэг агч, буйлс модны суулгацуудыг техникчийн зааварчилгааны дагуу амжилттай суулгасан ба ирэх гурван жилийн хугацаанд арчилгаа, тордолгоог Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэнгийн хамт олон хариуцах болсонг дуулгахад баяртай байна.



Хөгжлийн Шийдэл ТББ



Хөгжлийн Шийдэл ТББ нь Шинэлэг, Үр дүнтэй, Шилдэг шийдлээр өрх гэрийн амьдралын чанарыг сайжруулж, өсөлтөд чиглэсэн бизнесийн чадавхыг бий болгох, байгаль орчинд ээлтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих эрхэм зорилгын хүрээнд бичил болон жижиг дунд бизнесүүдэд бизнесийн болон ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх цогц үйлчилгээ үзүүлдэг, нийгэмд үйлчилдэг Төрийн Бус Байгууллага юм. Бид одоогоор Улаанбаатар хот болон орон нутгийн 14 салбар нэгж, 70 ажилтантайгаар бизнес хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2008 оноос бизнесийн сургалт, зөвлөх үйлчилгээ, төрийн болон олон улсын санхүүжилттэй бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлийн төсөл хөтөлбөрүүдийг тасралтгүй амжилттай хэрэгжүүлж ирсэн.

Бидний Нийгмийн хариуцлагын хүрээнд тогтмол хийдэг нэг ажил бол Хүүхдийг Ивээх Сантай хамтран Global Youth Entrepreneurship Challenge (GYEC) буюу Олон улсын өсвөрийн энтрепренерүүдийн уралдааныг 2017 оноос Монгол Улсад зохион байгуулж, улсаа төлөөлөх баг бэлтгэн олон улсын уралдаанд оролцуулж байна. Энэ жил зохион байгуулагдсан уралдааныг Хүүхдийг Ивээх сан, "Хөгжлийн шийдэл" ТББ, Нийслэлийн бизнес инновац хөгжлийн газар хамтран зохион байгуулсан.

Энэ уралдааныг Японы "Center for Entrepreneurship Development" болон Индонезийн "SURYA Institute"-ээс олон улсын түвшинд зохион байгуулдаг бөгөөд үр дүнд нь сурагчид Олон улсын өсвөрийн энтрепренерүүдийн уралдаанаас тулгамдсан асуудалд өсвөр үеийнхэн хамтран шийдэл хайх

нь ямар ач холбогдолтой, энтрепренер сэтгэлгээг түгээснээр нийгэмд ямар дэвшил авчирдаг талаар ойлгож, ирээдүйг илүү гэрэлтэй, өнгөлөг болгох хүсэл тэмүүлэлдээ хүрэх арга хэрэгсэл, ур чадваруудаа олж авдаг юм.

Хөгжлийн Шийдэл ТББ нийгэмд ээлтэй бизнесийн санааг хэрхэн олох, хөгжүүлэх, бизнесийн болон нийгмийн төлөөх ашгийн бус байгууллагуудад хэрхэн нийгэмд ээлтэй бизнес болж хувирахтай холбоотой сургалт, зөвлөх үйлчилгээг үзүүлж ажиллаж байна. Мөн нийгмийн хариуцлагын зардлаа нийгэмд ээлтэй хөрөнгө оруулалт болгон хувиргаж, нийгэмд ээлтэй бизнесүүдэд хөрөнгө оруулалт болгож өгөх сонирхолтой аж ахуйн нэгжүүдэд нийгэмд ээлтэй бизнесийн санаа, төслүүдийг хөгжүүлэх, шалгаруулах, санхүүжилт өгөхтэй холбоотой зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.



ХААН Банк



ХААН БАНКНЫ ХАМТ ОЛОН СЭЛБЭ ГОЛЫН ЭХЭНД ХОЁР ДАХЬ ЖИЛДЭЭ МОД ТАРИЛАА

ХААН Банкны тогтвортой хөгжлийн бодлого, компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч ХААН Банк Сангаас "ХААН Банкны ой" хөтөлбөр хэрэгжүүлж, сүүлийн 15 жилийн хугацаанд Монгол орон даяар нийт 29 мянга гаруй мод бут тариад байна.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2021 оноос эхлэн Улаанбаатар хотын Сэлбэ голын эх, Их баяны ам орчимд нөхөн сэргээлт нэн шаардлагатай 40 га газрыг ойжуулах ажлыг эхлүүлсэн бөгөөд тус аманд нийт 108 мянга орчим мод тарихаар төлөвлөөд буй билээ.

Иймээс ХААН Банкны 180 гаруй ажилтан 2022 оны 5 сарын 7-ны өдөр Мод тарих өдөрлөг зохион байгуулан хүлэмжинд хоёр жил бойжуулсан, бортоготой нарс модны суулгацыг мэргэжлийн хүмүүсийн заавар зөвлөгөөгөөр тарьсан юм.

ХААН Банк энэ жил 7 га талбайд тарилт хийх бөгөөд Нийслэлийн байгаль орчны газартай болон бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ирэх 3 жилийн хугацаанд арчилж, нөхөн тарьж, хяналт тавин ажиллана.

Сэлбэ голын эхийг ойжуулах энэхүү төсөл нь ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, усны ундаргыг сэргээх, улмаар Туул голд цутгах урсацыг нь нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Хамтын өсөлт төгөлдөр - ХААН Банк





Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий төслийн талбайд мод болон говийн онцлог ургамал тариалж байна.

Эрдэнэ Ресурс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтэд бэлтгэх зорилгоор мод, бут сөөг болон орон нутагт түгээмэл тархсан ургамлыг тарьж ургуулах ургамалжуулалтын хөтөлбөрийг эхлүүлээд байна. Компани нь хоёр га талбайд олон мянган суулгац, үр тариа тариална. 2022 онд 10,000 модны суулгац тарихаар төлөвлөсөн бөгөөд уурхай ашиглалтын явцад ургамалжуулалтын хөтөлбөрийг улам идэвхжүүлэх болно.

Бидний гол зорилго нь бүх оролцогч талуудын амьдрах орчинг сайжруулах, үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн экологийг дэмжихэд оршдог.

MSM ГРУППИЙН ХАМТ ОЛОН ЦССҮТ-Д ЦУСАА ХАНДИВЛАЛАА

MSM Групп нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Цус сэлбэлт судлалын үндэсний төв (ЦССҮТ)-тэй хамтран цусны донорын өдрийг зохион байгуулж, хамт олноороо цусаа хандивлан цусаа өгөх чухал хүмүүнлэгийн үйлсийг дэмжин ажиллалаа.

Тус цус цуглуулах арга хэмжээгээр нийт 60 гаруй ажилтан цусны донорын эгнээнд нэгдэж, цусаа өгсөн бөгөөд цугласан нийт цус, цусан бүтээгдэхүүн нь 180 гаруй хүнд нэн шаардлагатай тусламж болж хүрэх юм.



MSM ГРУПП МИШЭЭЛ ХҮҮХДИЙН САНТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Шүдний эмчилгээ, үйлчилгээ авах боломж хомс хөдөө орон нутгийн болон Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг, хороодын хүүхдүүдэд шүдний эмчилгээг үзүүлдэг Мишээл Хүүхдийн Сан нь Баянгол дүүргийн нийт 8 хорооны хүүхдүүдийг 2022 оны 4-р сарын 11-17-ны өдрүүдэд хүлээн авч, шүд амны хөндийн үзлэг оношилгоо, эмчилгээг үнэ төлбөргүй хүргэн ажиллалаа. MSM Групп нь Мишээл Хүүхдийн Сангийн хөдөө орон нутгийн хүүхдүүдийн шүдийг эмчлэх аянд Mercedes-Benz, Ford, Jeep зэрэг автомашинуудыг нийлүүлэн хамтран ажиллаж, үйл ажиллагааг нь дэмжин ирсэн юм. Бид Улаанбаатар хотын алсдагдсан дүүрэг, хороод руу чиглэсэн энэ удаагийн аяныг мөн дэмжин хамтран ажиллаж байна.



MSM ГРУПП ЛОТУС ХҮҮХДИЙН ТӨВИЙГ ДЭМЖИН АЖИЛЛАЛАА

MSM Групп Лотус Хүүхдийн Төвийн жил бүр зохион байгуулдаг хандив босгох зорилготой Гала үдшид оролцон, хамтран ажиллалаа.

Тус Гала үдшид Лотус Хүүхдийн Төвийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажилладаг байгууллага, хувь хүмүүс оролцон нийт 30 гаруй сая төгрөгийн хандивыг босгосон юм. Лотус Хүүхдийн Төв нь хүчирхийлэлд автсан, нийгмийн эмзэг давхаргын, нэн ядуу айлын хүүхдүүдийг халамжлан, асран хамгаалах, тэдний өдөр тутмын хэрэгцээг хангахын зэрэгцээ сурган хүмүүжүүлдэг төв юм.

MSM ГРУПП АМАРБАЯСГАЛАНТ ХИЙДИЙН ГЭРЭЛТҮҮЛГИЙН ТӨСЛИЙГ ДЭМЖИН АЖИЛЛАЛАА

MSM Групп "Бармид Аз" сангаас санаачлан хэрэгжүүлж буй Амарбаясгалант хийдийн гэрэлтүүлгийн төсөлд хандив босгох арга хэмжээнд оролцож, дэмжин ажиллалаа. "Бармид Аз" сан нь Монгол улсын соёлын өвийг хамгаалах зорилгоор 294 жилийн түүхтэй Амарбаясгалант хийдийн гадна, дотор гэрэлтүүлгийг шинэчлэн сайжруулах төслийг 2021 оны 8 сараас эхлүүлэн ажиллаж байгаа юм.



Энэхүү төслийн зорилго нь Амарбаясгалант хийдийн ховор нандин шүтээн, судар ном зэрэг соёлын үнэт өвийг хадгалан хамгаалж, одоогийн гэрэлтүүлгийг сайжруулах бөгөөд олон улсад энэ чиглэлээр мэргэшсэн зөвлөхүүдтэй хамтарч, стандартын дагуу дэвшилтэт технологид суурилсан гэрэлтүүлгийг ашиглах юм.

Тийсс компани Тийсс Кэер дархлаажуулалтын аянг хэрэгжүүлж байна

Тийссийн зүгээс орон нутагт эхлүүлсэн "Тийссийн дархлаажуулалтын аян"-ы хүрээнд Цогтцэций сумын хүүхдүүдэд хамгийн хэрэгцээтэй тэжээллэг хүнс, амин дэмийн багцыг бэлдэж өгч байна.

КОВИД-19 цар тахлын улмаас хил хаагдаж, уул уурхайн салбар уналтад орсноос үүдэн олон хүн ажил, орлогогүй болж, санхүүгийн болон эрүүл мэндийн хувьд хүндрэл бэрхшээлтэй тулгарч байгаа тул үүнийг даван туулахад туслах зорилгоор энэхүү дэмжлэгийг үзүүлж байгаа юм.

Тийсс компани, Цогтцэций сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, "Говийн залуучуудын хөгжлийг дэмжих төв" ТББ-тай хамтран хэрэгжүүлж



эхэлсэн тус аяны хүрээнд Өмнөговь аймгийн Ухаа Худаг уурхайн ойролцоох сумын 200 хүүхдэд 14 хоног тутамд дархлаажуулалтын багцыг бэлдэж өгч байгаа юм. Тэрээр 8 сарын хугацаанд хэрэгжих энэхүү санаачилга 2022 оны 6 сард хэрэгжиж дуусах юм.

ИТХ-ийн гишүүн О.Булгантуяа хэлэхдээ: "Тус сумын нутаг дэвсгэрт болон нүүрс



тээвэрлэлтийн зам дагуу ажиллаж, амьдардаг бөгөөд КОВИД-19 цар тахлын улмаас ажилгүй болсон, орлого багатай айл өрхүүдэд, мөн тэдгээр өрхийн (эрүүл мэндийн хувьд эрсдэлд орж болзошгүй) хүүхдүүдэд тус аяны хүрээнд тусламж үзүүлж байна.

Манай сум агаарын бохирдол болон орчны тоосжилт ихтэй, уушгины өвчлөлөөр улсдаа тэргүүлдэг.

"Тийссийн дархлаажуулалтын аян" нь хүүхдийн дархлааны тогтолцоог дэмжих хүнс, амин дэмээр хангахад чиглэсэн. Эдгээр дархлаажуулалтын багцыг айл өрх, хүүхдүүдэд албан ёсны оршин суух харьяалал харгалзалгүй олгож байгаа.

Хүүхдүүдэд амин дэм, тэжээллэг хүнс нэн чухал байдаг. Хүүхдүүд дархлаажуулалтын багцтай уутыг инээмсэглэн аваад, уутаа үүрэн баяртай гүйн явцгаахыг харах сайхан байдаг. Энэ аяныг дэмжин ажилласан Тийссийн хамт олонд чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье" гэв.



ХҮН БҮР ӨДӨР БҮР АЮУЛГҮЙ БАЙХ

Нүүрс тээврийн зам дагуу оршин суудаг харьяаллын бус бөгөөд сумын төвөөс алслагдан амьдардаг хүүхдүүд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тэр бүр хамрагдаж чаддаггүй. Тиймээс, Тийсс кээр төслийн баг ээлжит багцын тараалтаараа Цогтцэций сум дахь сум дундын эмнэлэгтэй хамтран ажиллаж, төсөлд хамрагддаг 34 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, амьсгалын замын асуудалтай байгаа илрүүлсэн бөгөөд цаашид нарийн шинжилгээнд хамруулах шаардлагатай байгаа гэдгийг зөвлөв. Багцын тараалтын явцад эрх нь зөрчигдсөн, эрүүл мэндийн онц ноцтой гэмтэл бэртэл авсан зэрэг хүүхдүүдийг олж тогтоож дараагийн шатны холбогдох төрийн байгууллагад шилжүүлэх тохиолдолд гарч байна.

Мөн, төсөлд хамрагддаг ихэнх хүүхдүүд сургууль болон цэцэрлэгээс завсардаж, гэртээ байдаг тул гал унтраах аврах ангийн байцаагч Л.Отгонцэрэн бяцхан хүүхдүүдэд гал болон гамшгийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах, ямар арга хэмжээг авах талаар сургалт зохион байгууллаа. Тус сургалтад 1-12 насны 19 хүүхэд хамрагдсан байна. Тийсс кээр төслийн багц нэг удаадаа нийт 200 хүүхэд хүрдэг бөгөөд хүүхдүүд ээлжит багцаа хүлээдэг, баяртайгаар хүлээн авдаг байдаг болсон.



ТИЙСС КЭЕР ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЯНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Нүүрс тээврийн зам дагуу оршин суудаг харьяаллын бус бөгөөд сумын төвөөс алслагдан амьдардаг хүүхдүүд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тэр бүр хамрагдаж чаддаггүй. Тиймээс, Тийсс кээр төслийн баг ээлжит багцын тараалтаараа Цогтцэций сум дахь сум дундын эмнэлэгтэй хамтран ажиллаж, төсөлд хамрагддаг 34 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, амьсгалын замын асуудалтай байгаа илрүүлсэн бөгөөд цаашид нарийн шинжилгээнд хамруулах шаардлагатай байгаа гэдгийг зөвлөв. Багцын тараалтын явцад эрх нь зөрчигдсөн, эрүүл мэндийн онц ноцтой гэмтэл бэртэл авсан зэрэг хүүхдүүдийг олж

тогтоож дараагийн шатны холбогдох төрийн байгууллагад шилжүүлэх тохиолдолд гарч байна. Мөн, төсөлд хамрагддаг ихэнх хүүхдүүд сургууль болон цэцэрлэгээс завсардаж, гэртээ байдаг тул гал унтраах аврах ангийн байцаагч Л.Отгонцэрэн бяцхан хүүхдүүдэд гал болон гамшгийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах, ямар арга хэмжээг авах талаар сургалт зохион байгууллаа. Тус сургалтад 1-12 насны 19 хүүхэд хамрагдсан байна. Тийсс кээр төслийн багц нэг удаадаа нийт 200 хүүхэд хүрдэг бөгөөд хүүхдүүд ээлжит багцаа хүлээдэг, баяртайгаар хүлээн авдаг байдаг болсон.

Тийсс компани Өмнөговь аймгийн ахмадын сувиллын байруудыг засварлахад дэмжлэг үзүүлээ

Монгол дах Тийссийн баг орон нутгийг дэмжих үүргийн хүрээнд Өмнөговь аймгийн төвд орших ахмадын хоёр сувиллыг сэргээн засварлахад тусламжийн гараа сунган оролцсон юм. Сувиллын байрууд өнгөрсөн жил Монгол орноор дайран өнгөрсөн хүчтэй салхи шуурга, аадар бороонд өртөж, эвдэрч гэмтсэн тул ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх боломжгүйд хүрсэн байжээ. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран манай баг дээвэр, цонхны эвдрэл, байрны гадна талыг бүхэлд нь засварлахад оролцож, дэмжлэг үзүүлсэн. Өмнөговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын

дарга Б.Должинсүрэн тус сувиллаар үйлчлүүлдэг бүх үйлчлүүлэгчийн өмнөөс Тийсс компанид талархлаа илэрхийлсэн юм. Должинсүрэн хэлэхдээ: “Өнгөрсөн оны буюу 2021 оны 7-р сард Өмнөговь аймгийн ихэнх сумдыг хамарч 3 өдөр үргэлжлэн орсон ширүүн борооны улмаас сувиллын газар үерт автаж, ахмадуудад үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл үүссэн. Гамшгийн үед гарсан хохирлыг арилгах санхүүжилт дутагдалтай тул бид хамтран ажилладаг аж ахуйн нэгж байгууллагуудаасаа тусламж хүссэн. Тийсс компани хүсэлтийг хүлээн авч, шаардлагатай дэмжлэг үзүүлсэнд баярлалаа” гэв.

Орон нутагт хувь нэмэр оруулах, орон нутгийн иргэдэд өгөөжтэй санаачилгыг дэмжих нь Тийсс компанийн хувьд урт хугацааны үр өгөөжийг бий болгоход чухал зүйл юм. Өмнөговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын сувилал нь 1997 оноос хойш жил бүр 450-550 хүн хүлээн авч сувилдаг байна. Тус сувилал нь хөгжөөнт уралдаан тэмцээн зохиохоос гадна эрүүл зөв хооллолт, нийгмийн халамжийн тухай хуулиар мэдээлэл сургалт, урлаг, соёлын арга хэмжээ зохион байгуулж, эмийн бус эмчилгээ үзүүлдэг юм.



Бадрах Энержи компани бизнесийн үйл ажиллагаагаа эерэгээр хүлээн зөвшөөрүүлж, удаан хугацаанд явуулахад төслийн оролцогч талуудтай яриа хэлэлцээ өрнүүлж, зөвлөлдөхийн сацуу мэдлэг, мэдээллээ хуваалцах ажлыг зохион байгуулах амлалт, үүрэг хүлээдэг.


Энэ ч үүднээс, орон нутгийн төр засгийн байгууллага, иргэдтэй тогтмол уулзалт хийж, ил тод байдлыг ханган нээлттэй харилцаа өрнүүлэх, санал солилцох, тэдэнд компанийн үйл ажиллагаа болон төсөлтэй холбоотой богино, дунд хугацааны төлөвлөгөөний талаар мэдээлэл өгөх зорилгоор Хамтын ажиллагааны зөвлөлийг 2013 онд Дорноговь аймгийн Улаанбадрах болон Сайншанд сумын Зүүнбаян багт байгуулсан билээ.



Зураг 1: Улаанбадрах сумын хамтын ажиллагааны зөвлөлийн хурал

2022 оны Хамтын ажиллагааны зөвлөлийн эхний улирлын уулзалтууд Зүүнбаян багт 2022 оны 4 дүгээр сарын 25-нд, Улаанбадрах суманд 5 дугаар сарын 19-ний өдөр тус тус боллоо.

2013 оноос Хамтын ажиллагааны зөвлөлийн хурлыг Улаанбадрах сум болон Зүүнбаян багт тус тус 26 удаа зохион байгуулаад байна.



Бадрах Энержи ХХК нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж эхэлсэн цагаас орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулсаар ирсэн. Компани Дорноговь аймгийн Улаанбадрах болон Сайншанд сумын Зүүнбаян багийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжсэн төсөл

хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирэв. Ингэхдээ тухайн орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагад тохирсон, олон ашиг хүртэгч бүхий эрүүл мэнд, байгаль орчин, усан хангамж, боловсролыг дэмжих төслүүдийг орон нутгийн оролцогч талуудтай харилцан зөвшилцөж хамтран хэрэгжүүлж ирлээ.

Бадрах Энержи ХХК орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжсэн төсөл, хөтөлбөрт 2006-2020 нийт 5,6 тэрбум төгрөгийг зарцуулсан бол, 2021 онд энэ дүн 181,4 сая төгрөг байлаа

БАДРАХ ЭНЕРЖИ ХХК ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН БОЛОВСРОЛД ХӨРӨНГӨ ОРУУЛЖ БАЙНА

Нүүрс тээврийн зам дагуу оршин суудаг харьяаллын бус бөгөөд сумын төвөөс алслагдан амьдардаг хүүхдүүд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тэр бүр хамрагдаж чаддаггүй. Тиймээс, Тийсс кээр төслийн баг ээлжит багцын тараалтаараа Цогтцэций сум дахь сум дундын эмнэлэгтэй хамтран ажиллаж, төсөлд хамрагддаг 34 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, амьсгалын замын асуудалтай байгаа илрүүлсэн бөгөөд цаашид нарийн шинжилгээнд хамруулах шаардлагатай байгаа гэдгийг зөвлөв. Багцын тараалтын явцад эрх нь зөрчигдсөн, эрүүл мэндийн онц ноцтой гэмтэл бэртэл авсан зэрэг хүүхдүүдийг олж тогтоож дараагийн шатны холбогдох төрийн байгууллагад шилжүүлэх тохиолдолд гарч байна.



Зураг 1: Улаанбадрах сумын хамтын ажиллагааны зөвлөлийн хурал

Мөн, төсөлд хамрагддаг ихэнх хүүхдүүд сургууль болон цэцэрлэгээс завсардаж, гэртээ байдаг тул гал унтраах аврах ангийн байцаагч Л.Отгонцэрэн бяцхан хүүхдүүдэд гал болон гамшгийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах, ямар арга хэмжээг авах талаар сургалт зохион

байгууллаа. Тус сургалтад 1-12 насны 19 хүүхэд хамрагдсан байна. Тийсс кээр төслийн багц нэг удаадаа нийт 200 хүүхдэд хүрдэг бөгөөд хүүхдүүд ээлжит багцаа хүлээдэг, баяртайгаар хүлээн авдаг байдаг болсон.

БАДРАХ ЭНЕРЖИ ХХК ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛЖ БАЙНА

Бадрах Энержи ХХК орон нутаг дахь төсөл хөтөлбөрийнхөө нэлээдгүй хувийг эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байна. Хамгийн сүүлийн жишээ нь компаниас Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн сум дундын эмнэлгийн физик эмчилгээний өрөөг тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах төслийн худалдан авалтыг хийж, 2022 оны 4 дүгээр сард бүрэн хүлээлгэн өглөө. Уг төслийг хэрэгжүүлснээр эмчийн хяналтан дор эмчлүүлэгчдийг нөхөн сэргээх эмчилгээнд хамруулж, эмчилгээний үр дүнг сайжруулан, цаашид эрүүл аж төрөх дадал сургах, халдварт бус өвчлөлийг бууруулах боломж бүрдэж байна. Компани Зүүнбаян багийн сум дундын эмнэлгийн материал, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах, эмч ажилтнуудын тасралтгүй боловсролыг дэмжих үүднээс 2008 оноос нийт 135 сая гаруй төгрөгийг зарцуулаад байна.



Зураг 3-4: Зүүнбаян багийн сум дундын эмнэлэгт физик эмчилгээний шаардлагатай тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгч байгаа нь

БАДРАХ ЭНЕРЖИ ХХК-ИЙН ХАМТЫН ОРОЛЦООТОЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН ХӨТӨЛБӨР



Бадрах Энержи ХХК 2013 оноос тус Хамтын оролцоотой байгаль орчны хяналтын хөтөлбөрийг Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян баг, Улаанбадрах сумын удирдлага, иргэд ба компани гэсэн гурван талт хамтын ажиллагаанд суурилан хэрэгжүүлж байна.

Тус хөтөлбөр нь төслийн талбай, түүний хүрээлэн буй орчны одоогийн төлөв байдлыг ажиглаж, судалгаа, хэмжилтийн ажил гүйцэтгэснээр ус, ургамал, хөрс зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд дэхь байгалийн өөрийн болон хүний хүчин зүйлээс үзүүлж буй нөлөөллийг үнэлж тогтоох зорилготой юм.

Түүнчлэн байгаль орчны хамгаалал, хяналт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэг, мэдээллийг олгох нь мөн хөтөлбөрийн зорилго юм.



Хамтын оролцоотой байгаль орчны хяналтын хөтөлбөр хэрхэн ажилладаг вэ? :

- Бадрах Энержи компанийн мэргэжилтнүүд, орон нутгийн иргэдийн төлөөлөл хамтран Аргалант, Баянбогд, Зүүнбаян багуудын нутаг дэвсгэр дээрх сонгосон цэгүүдээс ус, хөрс, ургамлын дээж авдаг. Үүнээс гадна талбай дээр цацрагийн хэмжилт гүйцэтгэдэг.
- Дээжийг нутгийн иргэдийн сонносон Геологийн төв лаборатори, Цөмийн судалгааны төвийн лаборатори руу шинжилгээнд явуулдаг.
- Хэмжилт, шинжилгээний үр дүнг оролцогч талуудад танилцуулж, тайлагнадаг.

Хамтын оролцоот байгаль орчны хяналтын хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэд хүсэлтээ Бадрах Энержи ХХК-ийн Байгаль орчин, цацрагийн хамгаалалт, Тогтвортой хөгжил, орон нутгийн багт шууд гаргах эсвэл өөрийн сум, багийн байгаль орчны мэргэжилтэн, нутгийн захиргаагаар дамжуулан гаргадаг. Хяналтын хөтөлбөр 2013 оноос улирал тутам тасралтгүй хийгдэж ирлээ (ковид цар тахал дэгдсэн 2021 оны оролцуулаагүй болно).

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН - 2022 ЧУУЛГАН

Иргэдэд санхүүгийн боловсролыг хүртээмжтэй түгээх зорилготой Монголын санхүү, хөрөнгийн зах зээлийн хамгийн том чуулган Хөрөнгө Оруулагч Үндэстэн - 2022 энэ жил Invest, Ignite, Inspire уриатайгаар 6 дахь удаагаа зохион байгуулагдаж, нийт 4,000 гаруй зочдод санхүүгийн боловсрол олгох арга хэмжээг олон нийтэд нээлттэй зохион байгуулсан.

Уг чуулган нь Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох зорилгын хүрээнд 2016 оноос хойш зохион байгуулагдах бүртээ санхүү, хөрөнгө оруулалтын салбарын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн талаар салбар бүрийн төлөөллүүдийн оролцоо бүхий хэлэлцүүлэг өрнүүлдэг уламжлалтай бөгөөд хөрөнгийн зах зээлийн тухай мэдлэг, мэдээлэл, санхүүгийн боловсролыг олон нийтэд хүртээмжтэйгээр түгээсээр ирсэн юм.





ВИЕРНЕЗ-СТАРЧЕЙЗ КОМПАНИ “МОНГОЛЫН ТЭРГЭНЦЭРТЭЙ ТУЯЛЗУУР СЭЛЭМНИЙ ХОЛБОО”- Г ДЭМЖИН АЖИЛЛАА.






























































Жил бүр зохион байгуулагддаг “Тэргэнцэртэй Туялзуур Сэлэмний Аварга шалгаруулах тэмцээн” -ийн В зэрэглэлийн тамирчдын ээлжит тэмцээнийг Porsche Улаанбаатар төвийн хамт олон амжилттай хамтран зохион байгууллаа. Тус тэмцээнийг Porsche Улаанбаатар төв нь 2019 оноос эхлэн дэмжиж, хамтран зохион байгуулж эхэлсэн билээ. Тэргэнцэртэй туялзуур сэлэмний спорт нь эрч хүчтэй, хурдан хэмнэлтэй спорт бөгөөд энэхүү тэмцээн нь манай тамирчдын хувьд 2024 оны Парисын Пара-олимпийн наадамд нэг алхам ойртсон, чансааны тэмцээн байснаараа онцлогтой, утга учиртай болж өнгөрлөө. Старчейз Монголиа Групп нь “Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Холбоо” зэрэг зорилтот бүлгийг дэмжин, урамшуулдаг байгууллагийг дэмжин ажиллахдаа үргэлж таатай байх болно.



“PORSCHE ХҮҮХДИЙН ЖОЛООДЛОГЫН СУРГАЛТ” 2022

“Porsche Улаанбаатар Төв”-өөс уламжлал болгон зохион байгуулдаг “Porsche Хүүхдийн Жолоодлогын Сургалт” 2022 арга хэмжээ маань “Өнөр Бүл” Хүүхдийн төвийн бяцхан жолоочидтой хамт амжилттай зохион байгуулагдлаа. Хүүхдүүд маань Замын Хөдөлгөөний дүрэм, явган зорчигч хэрхэн аюулгүй зорчих мөн гарцаар гарахын давуу тал зэрэг олон мэдэлгүүдийг сурч үүнийгээ практикт суралцаж бататгасан юм. Бяцхан зорчигчдын замын хөдөлгөөний аюулгүй байдал юунаас ч эрхэм бөгөөд энэ асуудалд өөрсдийн хувь нэмэрээ оруулж байгаадаа бид үргэлж баяртай байх болно.

AmCham Members in 2022

				
Altai Holding	Anderson & Anderson	ARD Insurance	BadraKh Energy	Bartoworld Mongolia
				
Bloomberg TV Mongolia	Capitron Bank	Cummins Mongolia	DB & GTS	Development Solutions
				
Erdena Resource Development	Ernst & Young	Facebook	GE	Gem International
				
Gobi	Golomit Bank	Golomit Capital	Gund Investment	Herbalife Nutrition
				
High Payment Solutions	Hunnu Resources	International School of Ulaanbaator	InvestCore	Khaljin Tugul
				
Khan Bank	MACU	Magnol Trade	MahoneyUjataa	Mandal Insurance
				
MCS Holding LLC	Milvia & Erdenebatai	Metro Express	Mik Group	Minter Ellison
				
Monopolynet Group	MSM Group	Nano International	Naran Mandal	Obortech Mongolia
				
Onch & Company	Oriflame Mongolia	Oyu Talgai	Pai Matrix LLC	Petro Mataad
				
Philip Morris	PWC Mongolia	Redpath Mongolia	Rio Tinto	S & Royal Group
				
Sandvik	Seruun Group	Shangri-La Ulaanbaator	Skytel	South Gobi Sands LLC
				
State Bank of Mongolia	Steppe Group	Tanian Express LLC	Terra Explorers LLC	The Blue Sky
				
Thiess	Trade & Development Bank	Trafigura	Trans Bank	Transwest Mongolia
				
Turkish Airlines	Tushig Group	United Machinery Inc	Visa	Woomer-Starchose
				
Woodmont International	Xacbank			